

2 COVID-19 ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ Эерэг бай

Бага эсвэл өсвөр насны хүүхдүүд тань галзууруулах шахаж байхад эерэг байх хэцүү. "Болиод өгөөч!" гэж арга барж байна уу. Байзаарай, хэрэв бид зөв зааварчилж чадвал хүүхэд эцэг эхийнхээ үгийг дагах хандлагатай байдаг. Мэдээж, тэдний сайн үйлдлийг магтан, урамшуулах шаардлагатай.

Та тэднээс ямар зан араншин хүлээдгээ ойлгуул


Хүүхдүүддээ юу хийхийг нь заахдаа эерэг үгсийг ашигла: «Хувцсаа битгий хөглөрүүлээд бай гэхийн оронд «хувцсаа сайхан хураачих» гэх мэтээр

Үгээ яаж хэлэхээс их юм шалтгаална.

Хүүхдээ хашгирч загнах нь таныг болон тэднийг улам бүхмдүүлж, зовооно. Нэрээр нь дуудаж тэдний анхаарлыг тат. Тэгээд тайван зөвлөн дуугаар яриарай.

Хүүхдийнхээ зөв зан үйлийг магтан урамшуул

Тэд таны нүднээс далд сайн үйл хийхэд нь магтан сайшаа. Ингэснээр та тэднийг анзаарч, анхаарал тавьдаг гэдгээ ойлгуулна.



Бодитоор ханд

Таны хий гэсэн бүх зүйлийг хүүхэд чинь хийж чадах уу? Бүх л өдрийн турш гэртээ чимээгүй суух нь хүүхдүүдэд боломжгүй шүү дээ. Тиймээс зөвхөн таныг утсаар ярих үед чимээгүй байхыг хүсэх нь илүү бодитой.

Өсвөр насны хүүхдэдээ найз нөхөдтэйгөө холбоотой байхад нь тусла

Өсвөр насны хүүхдүүд найз нөхөдтэйгөө харилцах хэрэгцээтэй байдаг. Тиймээс нийгмийн сүлжээ болон бусад зайнаас харилцах аюулгүй арга замаар найзуудтайгаа холбоотой байхад нь тусла. Хамтдаа үүнийг хийж болно шүү дээ!

